



IV/2023


Тархаасан: 2023 оны 5 дугаар сарын 08



## Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.3 хувиар өслөө

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 11.3 хувь, өмнөх оны эцсээс 4.7 хувь, өмнөх сараас 1.3 хувиар өссөн байна.

ЗУРАГ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 17.0 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 19.5 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 13.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 6.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 13.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 6.7 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 4.0 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 24.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 4 дүгээр сард өмнөх оны эцсээс 4.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 11.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 2.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 1.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 3.5 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 2.6 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ 6.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 4 дүгээр сард өмнөх сараас 1.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.6 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 3.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2023 оны 4 дүгээр сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	<u>2023 IV</u> 2022 IV	<u>2023 IV</u> 2022 XII	<u>2023 IV</u> 2023 III
<b>Ерөнхий индекс</b>	<b>100.0</b>	<b>111.3</b>	<b>104.7</b>	<b>101.3</b>
Хүнсний бараа, ундаа, ус	25.1	117.0	111.4	103.3
Согтууруулах ундаа, тамхи	1.2	108.1	102.3	100.3
Хувцас, бөс бараа, гутал	12.3	113.2	102.6	100.9
Орон сууц, ус, цахилгаан, түлш	10.3	106.7	101.4	100.3
Гэр ахуйн тавилга, бараа	5.4	113.0	103.5	100.6
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	7.3	106.7	102.6	100.6
Тээвэр	16.3	104.0	100.1	99.6
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	5.9	101.4	100.1	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	1.9	109.2	101.4	100.5
Боловсролын үйлчилгээ	5.2	106.7	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.9	124.0	110.9	103.6
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	0.5	106.8	106.7	100.0
Бусад бараа, үйлчилгээ	5.7	121.5	106.3	101.8

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 4 дүгээр сард 15.8 хувь гарсан бол 2023 оны 4 дүгээр сард 11.3 хувь болж, өсөлтийн хурдац өмнөх оны мөн үеэс 4.5 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 2. ИНФЛЯЦАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГҮҮДИЙН ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, нэгжээр, жил бүрийн 4 дүгээр сард

Бараа, үйлчилгээний бүлэг	2021 IV	2022 IV	2023 IV	Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд 11.3 хувь гарсны 4.7 (41.6%) нэгж хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.
<b>Ерөнхий индекс</b>	<b>5.2</b>	<b>15.8</b>	<b>11.3</b>	
Хүнсний бараа, ундаа, ус	3.2	4.8	4.7	
Согтууруулах ундаа, тамхи	0.0	0.1	0.1	
Хувцас, бөс бараа, гутал	0.3	1.6	1.5	
Орон сууц, ус, цахилгаан, түлш	0.4	1.4	0.7	
Гэр ахуйн тавилга, бараа	0.2	0.7	0.7	
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.2	1.6	0.5	
Тээвэр	0.2	3.9	0.7	
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.0	0.1	0.1	
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.0	0.1	0.2	
Боловсролын үйлчилгээ	0.0	0.2	0.3	
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	0.2	0.4	0.7	
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	0.0	0.1	0.0	
Бусад бараа, үйлчилгээ	0.3	0.8	1.2	


ХҮСНЭГТ 3. ИНФЛЯЦАД ИМПОРТЫН БАРААНЫ ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, жил бүрийн 4 дүгээр сард, нэгж хувиар

Үзүүлэлт	2021 IV		2022 IV		2023 IV	
	Нэгж хувь	Хувь	Нэгж хувь	Хувь	Нэгж хувь	Хувь
<b>Ерөнхий индекс</b>	<b>5.2</b>	<b>100.0</b>	<b>15.8</b>	<b>100.0</b>	<b>11.3</b>	<b>100.0</b>
Импортын барааны нөлөө	1.8	34.6	9.5	60.1	4.8	42.5

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 410 нэр төрлийн бараа, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 404 нэр төрлийн бараа, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 410 нэр төрлийн бараа, үйлчилгээний 221 нь импортын бараа байгаа бөгөөд энэ нь нийт жингийн 46.0 хувийг эзэлж байна.

Инфляц 2023 оны 4 дүгээр сард 11.3 нэгж хувь гарсны 4.8 (42.5%) нэгж хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

ЗУРАГ 2. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) сараар, хувиар




Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2022 оны 4 дүгээр сард 17.3 хувиар, 2023 оны 4 дүгээр сард 16.7 хувиар өсөж, өсөлтийн хурдац 0.6 нэгж хувиар, хүнсний бус бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2022 оны 4 дүгээр сард 15.2 хувиар, 2023 оны 4 дүгээр сард 9.1 хувиар өсөж, өсөлтийн хурдац 6.1 нэгж хувиар тус тус буурчээ.

ХҮСНЭГТ 4. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 4 дүгээр сард (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), бүлгээр, хувиар

Огноо	Хүнс, хүнсний бус	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	<b>Ерөнхий индекс</b>	<b>115.8</b>	<b>115.7</b>	<b>116.2</b>	<b>114.3</b>	<b>117.6</b>	<b>115.7</b>
2022 IV	Хүнс	117.3	118.2	117.5	116.7	116.0	113.5
	Хүнсний бус	115.2	114.8	115.7	113.3	118.4	116.8
	<b>Ерөнхий индекс</b>	<b>111.3</b>	<b>110.9</b>	<b>111.0</b>	<b>113.3</b>	<b>111.4</b>	<b>111.3</b>
2023 IV	Хүнс	116.7	115.6	116.1	121.8	116.1	118.5
	Хүнсний бус	109.1	109.1	109.0	109.7	109.2	108.1

Хүнсний бүлгийн үнэ 2023 оны 4 дүгээр сард Хангайн бүсэд өмнөх оны мөн үеэс 21.8 хувь, хүнсний бус бүлгийн үнэ 9.7 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 3. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 4 дүгээр сард (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувиар




Барааны бүлгийн үнэ 2022 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 18.2 хувиар, 2023 оны 4 дүгээр сард 12.5 хувиар өсөж, өсөлтийн хурдац 5.7 нэгж хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ 2022 оны 4 дүгээр сард 8.5 хувиар, 2023 оны 4 дүгээр сард 7.4 хувиар өсөж, өсөлтийн хурдац 1.1 нэгж хувиар тус тус буурчээ.

ХҮСНЭГТ 5. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 4 дүгээр сард (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувь, бүсээр

Огноо	Бараа, үйлчилгээ	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	<b>Ерөнхий индекс</b>	<b>115.8</b>	<b>115.7</b>	<b>116.2</b>	<b>114.3</b>	<b>117.6</b>	<b>115.7</b>
2022 IV	Бараа	118.2	118.3	118.7	116.6	120.5	117.9
	Үйлчилгээ	108.5	109.2	107.2	105.9	107.8	108.2
	<b>Ерөнхий индекс</b>	<b>111.3</b>	<b>110.9</b>	<b>111.0</b>	<b>113.3</b>	<b>111.4</b>	<b>111.3</b>
2023 IV	Бараа	112.5	111.7	112.3	115.2	113.5	113.2
	Үйлчилгээ	107.4	108.7	105.7	105.7	103.7	103.5

Хангайн бүсэд барааны бүлгийн үнэ 2023 оны 4 дүгээр сард 15.2 хувь, Улаанбаатар хотод үйлчилгээний бүлгийн үнэ 8.7 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 4. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2023 оны 4 дүгээр сард өмнөх сараас 8.6 хувиар өсөхөд хонь, ямааны махны үнэ дунджаар 10.5 хувь, үхрийн махны үнэ 10.1 хувь, адууны махны үнэ 6.3

хувиар өссөн нь, харин өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар өсөхөд үхрийн махны үнэ 10.9 хувь, хонь, ямааны махны үнэ 6.7 хувиар, адууны махны үнэ 13.9 хувиар өссөн нь тус тус голлон нөлөөлжээ.

**Улаанбаатар хот:**


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2023 оны 4 дүгээр сард өмнөх сараас 1.4 хувь, өмнөх оны эцсээс 5.1 хувь, өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар өслөө.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 15.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 8.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 15.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 7.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 5.7 хувь, тээврийн бүлгийн үнэ 3.0 хувь, боловсролын бүлгийн үнэ 10.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 24.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 4 дүгээр сард өмнөх оны эцсээс 5.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 12.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 1.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 3.3 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 2.2 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 12.6 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ 2.8 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 4 дүгээр сард өмнөх сараас 1.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 3.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.3 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 4.1 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

**ЗУРАГ 5. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС сараар (өмнөх оны мөн үеэс), хувиар**




Улаанбаатар хотод 2023 оны 4 дүгээр сард хэрэглээний сагсны 404 нэрийн бараа, үйлчилгээнээс 136 (33.7%) бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас өсөж, 25 (6.2%) бараа, үйлчилгээний үнэ буурч, 243 (60.1%) бараа, үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байна.

ЗУРАГ 6. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЦУЛ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ 2023 оны 4 дүгээр сард 18841 төгрөг болж, 2021 оны 4 дүгээр сараас 18.4 хувиар, 2022 оны 4 дүгээр сараас 12.4 хувиар, өмнөх сараас 1839 (10.8%) төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 7. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ 2023 оны 4 дүгээр сард 16747 төгрөг болж, 2021 оны 4 дүгээр сараас 20.9 хувиар, 2022 оны 4 дүгээр сараас 15.2 хувиар, өмнөх сараас 1675 (11.1%) төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 8. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр



Улаанбаатар хотод худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2023 оны 4 дүгээр сард 14062 төгрөг болж, 2021 оны 4 дүгээр сараас 14.2 хувиар, 2022 оны 4 дүгээр сараас 11.4 хувиар, өмнөх сараас 1242 (9.7%) төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 9. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ НЭГ ЛИТР АИ-92 БЕНЗИНИЙ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ 2023 оны 4 дүгээр сард 2390 төгрөг болж, 2021 оны 4 дүгээр сараас 65.5 хувь, 2022 оны 4 дүгээр сараас 0.3 хувиар өссөн байна.

**Аймаг:**

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 4 дүгээр сард бүх аймагт өмнөх оны мөн үеэс 9.3-14.8 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 4 дүгээр сард Баян-Өлгий аймагт 9.3 хувиар өссөн нь хамгийн бага, Өвөрхангай аймагт 14.8 хувиар өссөн нь хамгийн өндөр байна.


ЗУРАГ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 2023 оны 4 дүгээр сард (өмнөх оны мөн үеэс), хувь, аймаг, нийслэлээр



Аймгуудад худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2023 оны 4 дүгээр сард 11153 төгрөг болж, 2022 оны 4 дүгээр сараас 199 төгрөгөөр өссөн байна.

Хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2023 оны 4 дүгээр сард Увс аймагт 9261 төгрөг байгаа нь хамгийн бага, Ховд аймагт 13000 төгрөг байгаа нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 11. АЙМГУУДАД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 4 дүгээр сард, төгрөгөөр





### Ойлголт, тодорхойлолт:

**Хэрэглээний сагс:** Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно

**Хэрэглээний бараа, үйлчилгээний жин:** Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

**Хэрэглээний үнийн индекс:** Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

### Тооцох аргачлал:

Хэрэглээний үнийн индексийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейрсийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left( \frac{P_{it}}{P_{i,t-1}} \right) \left( \frac{P_{i,t-1}}{P_{i,t-2}} \right) \dots \left( \frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left( \frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

$I_{ct}^L$  – тайлант үеийн хувиргасан Ласпейрсийн индекс (t)

t – тайлант үе

i – бараа, үйлчилгээ

o – суурь үе

$P_t^i$  – i барааны тайлант үеийн үнэ

$P_0^i$  – i барааны суурь үеийн үнэ

$Q_0^i$  – i барааны суурь үеийн жин

Хэрэглээний үнийн индексийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг.

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 404 бараа, үйлчилгээ (аймагт 313 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2018, 2019, 2020 оны дундаж үр дүнгээр жинг тооцон, 2020 оны шинэчилсэн суурьтайгаар 2022 оны 8 дугаар сараас эхлэн тархааж байна.

Хэрэглээний үнийн индексийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан. Мөн аймгийн дундаж үнийг тооцохдоо сонгогдсон 112 сумын үнийн мэдээллийг хамруулж байна.

Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн барааны үнийг сум, аймаг, дүүрэг, нийслэлээс сар бүр цуглуулж байна.



**Эх үүсвэр:**

ҮСХ, Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээ

**Ангилал, код:**

Хувийн зориулалттай бараа, үйлчилгээний ангилал

**Мэдээлэл авах холбоос:**

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:**

2023 оны 6 дугаар сарын 05

Эдийн засгийн статистикийн газрын даргын  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  
Э.Мягмарханд  
Утас : (976-11)-261563

Эдийн засгийн статистикийн газрын  
статистикч Д.Батсүх, Х.Хонгорзул  
Утас : (976-51)-261559

